

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны дүгээр
сарын -ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг үндэслэн, “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-иас ирүүлсэн хүсэлтийг хянан хэлэлцээд Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Өмнөговь аймгийн Ханбогд сумын Гашуун сухайт хилийн боомт болон Хайрхан багийн хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тарифыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Батлагдсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК /Т.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ тариф, зах зээлийн газар /Б.Болор-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГА

А.ТЛЕЙХАН

ЗОХИЦУУЛАГЧ

Э.ТҮВШИНЧУЛУУН

ЗОХИЦУУЛАГЧ

Б.БАТТУЛГА

ЗОХИЦУУЛАГЧ

У.МЯГМАРСҮРЭН

ЗОХИЦУУЛАГЧ

Б.АМАРСАНАА

Эрчим хүчний зохицуулах хорооны
2019 оны дүгээр сарын -ны өдрийн
.... дугаар тогтоолын хавсралт

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ГАШУУН СУХАЙТ ХИЛИЙН
БООМТ БОЛОН ХАЙРХАН БАГИЙН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ
ЦАХИЛГААНЫ ТАРИФ**

1. Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага болон айл өрхөд борлуулах цахилгааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	Уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэр, Үүнд, <i>Нүүрс олборлолт, боловсруулалт</i> <i>Газрын тос, шатдаг хий олборлолт, боловсруулалт</i> <i>Төмрийн хүдэр олборлолт, боловсруулалт</i> <i>Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолт</i> <i>Бусад ашигт малтмал олборлолт, боловсруулалт</i>	Төг/кВт.ц	330.54
2	Бусад үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага	Төг/кВт.ц	330.54
3	Айл өрх	Төг/кВт.ц	154.08

--- оОо ---